



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

Жилийн тайлан 2014

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД



Жилийн тайлан 2014

Швейцарийн хөгжлийн агентлаг

Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай Плаза бизнес төв
Олимпийн гудамж 12, 1-р хороо,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар,
Монгол Улс

Ш/х 37
Улаанбаатар 14210
Монгол улс

Утас: 976 11 331422
Факс: 976 11 331420
Э-шуудан: ulaanbaatar@eda.admin.ch

Вэб: www.eda.admin.ch/mongolia

Гэрэл зураг & Эх бэлтгэл

Швейцарийн хөгжлийн агентлаг
Гамма агентлаг

Хавтасны зураг © А.Батжаргал (iRMUUN)

Хэвлэлт

Гамма агентлаг



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development
and Cooperation SDC**
Швейцарийн хөгжлийн агентлаг

Жилийн тайлан 2014

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД

Агуулга

Удиртгал	2
ШХА-ын 2014 оны онцлох үйл явдал	4
■ Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал	6
■ Мэргэжлийн боловсрол, сургалт	10
■ Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо	14
■ Тогтвортой бичил уурхай	18
2015 оны төлөв байдал	22

Удиртгал

2014 онд Швейцарь, Монгол хоёр улс дипломат харилцаа тогтоосны 50 жил, хөгжлийн хамтын ажиллагааны 10 жилийн ой давхар тохиож, хамтатган тэмдэглэж өнгөрүүлээ. Швейцарь, Монгол хоёр орон дипломат харилцаа тогтоосноос хойш найрсаг харилцаагаа хөгжүүлэн бататгаж 2008 оноос эхлэн хоёр жил тутамд улс төрийн яриа хэлэлцээр тогтмол хийж ирсний хамгийн сүүлийнх нь 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Берн хотод зохион байгуулагдсан. Швейцарийн Засгийн газар өөрийн төлөөлөгчийн газар болох Швейцарийн хамтын ажиллагааны газрыг 2004 онд Улаанбаатар хотноо нээн ажиллуулсан бөгөөд урт хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдээрээ дамжуулан Монгол улсын өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад дэмжлэг үзүүлж байна.

2014 оны сүүлээр Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн тэргүүлсэн Засгийн газар огцорлоо. Сөрөг хүчний зүгээс огцруулах шалтгаан нь эдийн засгийн уналтыг зогсоож чадаагүй, авлига хээл хахууль, танил талын хэрэгт орооцолдсон хэмээн үзсэн бөгөөд түүнийг нь эрх баригч намын зарим гишүүд дэмжсэнээр Шинэчлэлийн хэмээх тодотголтой Засгийн газар огцорсон. Эрх баригч Ардчилсан Нам (АН) дараагийн Ерөнхий сайдаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан Ч. Сайханбилэгийг томиллоо. Шинээр томилогдсон Ерөнхий сайд өөрийн танхимд УИХ-д суудалтай улс төрийн бүх намын төлөөллийг урин эвслийн засгийн газар



© ШХА

Швейцарийн Берн хотын Байгалийн түүхийн музейд дэлгээгдсэн "Швейцарь, Монгол орон гэрэл зургийн дуранд" үзэсгэлэн (2014 оны 9 сар)

байгуулсан бөгөөд энэ алхамаа "Шийдлийн засгийн газар" гэж нэрлэлээ. Эдийн засгийг сэргээн урагшлуулах үндсэн зорилго бүхий энэхүү шинэ Засгийн газар 19 сайд, 15 яамтай ажиллана. Сайд нарын арвыг Ардчилсан Намаас, зургааг Монгол Ардын Намаас (МАН), үлдсэн гурвыг Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН), Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН)-ын Шударга ёс эвслээс томилжээ.

ШХУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн ёслолын ажиллагааны үеэр (2014 оны 5-р сарын 22)



© ШХА



Монгол Улсын эдийн засаг сүүлийн хэдэн жил хоёр оронтой тоогоор өсч (2011 онд 17 гаруй хувь, 2012, 2013 онд тус тус 12 орчим хувь) байсны эцэст 2014 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) буурсан, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ унасан зэрэгтэй холбоотойгоор уналтад орлоо. 2014 онд ГШХО 60 гаруй хувиар буурсан нь гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах орчин тогтворгүй байсан, Засгийн газар тус улсын хамгийн том хөрөнгө оруулагч Рио-Тинто-ой Оюу Толгойн төслийн асуудлаар маргаантай хэвээр байгаатай ихээхэн холбоотой гэдэгтэй шинжээчид санал нэг байна. Оюу толгойн асуудлаарх хөрөнгө оруулагчдын болон Засгийн газрын байр суурь зөрөөтэй байх тусам тус төслийн хоёр дахь үе шат буюу далд уурхайн бүтээн байгуулалтад оруулах таван тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хойшилж, хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэхгүй байх талтай. Дотоодын хавтгайрсан татаасын хөтөлбөрүүдийн улмаас улсын өр өссөн, экспортын орлого, ГШХО буурсан зэргээс үүдэн тус улсад төлбөрийн тэнцэлийн хямрал нүүрлэхэд ойрхон байна. Хэдийгээр 2014 онд эдийн засгийн өсөлтийн хувь 7-8 хувьтай гарахаар тооцоолж байгаа ч Олон Улсын Валютын Сангаас санхүүгийн дэмжлэг авахаас ч өөр аргагүй байдалд хүрч болох талтай.

Монгол Улс олон улсын харилцааны прагматик арга барил баримталдаг ч эдийн засгийн хүндрэлийн үед "гуравдагч хөршийн бодлого"-ын үр нөлөө хязгаарлагдмал болохыг мэдэрлээ. Монгол Улсад хөрш хоёр гүрэн ОХУ, БНХАУ-ын Ерөнхийлөгч нар 2014 оны

найм, есдүгээр саруудад шил дараалан айлчилж худалдаа, эрчим хүч, уул уурхай, санхүүгийн салбарын хамтын ажиллагаа, дэд бүтцийн хөгжлийн асуудлаар хоёр талын хамтын ажиллагааны гэрээнүүд байгууллаа. Түүнчлэн БНХАУ-тай байгуулсан хоёр талын гэрээний хүрээнд хөнгөлөлттэй зээлийн багц санал болгосны зэрэгцээ Монгол Улсын төв банктай своп солилцооны гэрээ байгуулах замаар төлбөрийн тэнцэлд нүүрлээд байсан хямралыг хойшлуулж чадлаа. Эдгээр үйл явдал нь Монгол Улсын баримталдаг "гуравдагч хөршийн бодлого"-д цэг тавих хэмжээний ач холбогдолгүй боловч эдийн засгийн хямралын үед, нэн ялангуяа "гуравдагч хөрш" гээд байгаа улсуудаас нэн шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа нөхцөлд энэ бодлого үр нөлөөгүй болохыг харууллаа.

Монгол дахь Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2016 оны стратеги хэрэгжиж эхлээд даруй хоёр жил өнгөрлөө. Тус стратеги нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн эрх тэгш, тогтвортой өсөлтөд хувь нэмрээ оруулах зорилготой. Энэ нь 1) Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал (ХАА); 2) Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС); 3) Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо (Засаглал) гэсэн гурван үндсэн чиглэлд тулгуурлаж байна. Түүнчлэн ШХА-ийн Монгол дахь хөтөлбөрөөс хувиараа ашигт малтмал олборлолт, бичил уурхайн салбарт (ТБУ) ихээхэн хөрөнгө оруулж байгаа нь хөдөө, орон нутгийн иргэдийн ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй юм.

© ШХА

ХАА бол Монгол Улсын эдийн засгийн тулгуур багана

2014 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН



ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

ШХА-аас өнгөрсөн арван жилийн турш дэмжлэг үзүүлсний дүнд Монгол Улс дотоодынхоо төмсний хэрэгцээг бүрэн хангах чадвартай боллоо. Төмсний сортыг туршин нутагшуулах, үр үржүүлэх, тариалах арга техникт дэмжлэг үзүүлэх, тариаланч механикчдын ур чадварыг дээшлүүлэх, хадгалах байгууламж, маркетингийн арга ухааныг сайжруулах замаар тус салбарын чадавхийг бэхжүүлээд байна. 2014 онд явуулсан зардал, үр ашгийн шинжилгээгээр арван жилийн өмнө Швейцарийн дэмжлэгтэйгээр нэвтрүүлсэн үр үржүүлэх тогтолцоо нь эдийн засгийн болон санхүүгийн хувьд тогтвортой хөгжих чадвартай болохыг нотолсон байна.



МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ:

Монгол Улс эрэлтэд чиглэсэн МБС-ын тогтолцоог нэвтрүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гаргаад байна. ШХА-ийн төслөөс ажил олгогчдын шаардлагыг хангасан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн арга зүй, загварыг боловсруулж, улмаар тэдгээрийг Хөдөлмөрийн сайдын тушаалаар үндэсний хэмжээнд мөрдлөг болгохоор баталлаа. Тэрхүү арга зүйн дагуу, МБС-ын байгууллагууд ажил, мэргэжлийн стандартад суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтандаа ашиглах юм.



ЗАСАГЛАЛ:

Орон нутгийн хөгжлийн хөгжлийн төлөвлөлтөд оролцох иргэдийн тоо нэмэгдэж, иргэдийн нийтийн хэлэлцүүлгийн чанарт ахиц гарлаа. Худалдан авалтын ажиллагааг илүү өрсөлдөөнтэй, ил тод болгосноор төсвийн хөрөнгөөр хийгдэх ажил үйлчилгээний зардал буурлаа. ШХА-аас орон нутгийн төсвийн 64 хэлэлцүүлэг зохион байгуулахад тусласны үр дүнд иргэдийн нэн тэргүүнд ач холбогдолтой гэж сонгосон 313 төсөл (найман тэрбум төгрөгийн өртөгтэй) хэрэгжих боллоо. Нийт 13 аймгийн дүнгээр төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын зардал дунджаар 10-15 хувь буурсан тооцоотой байна.



ТОГТОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ:

2014 онд ШХА-ийн дэмжлэгтэйгээр дараахь үр дүн гарлаа. Үүнд: Ашигт малтмалын тухай шинэ бодлого, хуулийн шинэ нэмэлт өөрчлөлтөд бичил уурхайн асуудал тусгагдлаа. Бичил уурхай эрхлэгчдийн орлого нэмэгдэж амьжиргаа дээшилж, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдсан бичил уурхайчдын тоо нэмэгдэж, бичил уурхайгаас борлуулсан алтны хэмжээ эрс нэмэгдэж, бичил уурхай эрхлэх эрх бүхий газрын нутгийн хэмжээ нэмэгдэж, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэдлэг, практик хэрэглээ дээшилсэн нь осол аваарын тоо буурснаас харагдаж байна.



Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал



Хөтөлбөрийн ОНЦЛОХ үр дүн:

ШХА-аас өнгөрсөн арван жилийн турш дэмжлэг үзүүлсний дүнд Монгол улс дотоодынхоо төмсний хэрэгцээг бүрэн хангах чадвартай боллоо. Төмсний сортыг туршин нутагшуулах, үр үржүүлэх, тариалах арга техник, тариаланч механикчдын ур чадварыг дээшлүүлэх, хадгалах байгууламж, маркетингийн арга ухааны сайжруулах замаар төмсний салбарын чадавхийг системтэйгээр бэхжүүллээ.

ШХА-ийн дэмжлэгтэй Бэлчээр ашиглагчдын хэсгүүдээр (БАХ) дамжуулан Монголын баруун аймгуудад бэлчээрийн тогтвортой удирдлагын систем бий болгож чадлаа. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гаргаж, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулан орон нутгийн удирдлагуудаар албан ёсоор батлуулах замаар нийт 29,3 га бэлчээрийг (нийт газар нутгийн 20 орчим хувь) БАХ-ийн толголцоонд хамрууллаа. Түүнчлэн малчдын хоршоод, БАХ-ийн толголцооны хэлхээ холбоог тасралтгүй өргөжүүлснээр малчдын орлого нэмэгдэж байна. Мөн сарлагийн хөөврийн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх анхны туршилтууд үр дүнтэй болох нь харагдаж байна.

Монгол Улс хүн, малын эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг халдварт бруцеллёз өвчинд нэрвэгдсэн хэвээр байна. 2014 онд ШХА-ийн дэмжлэгтэйгээр бруцеллёзийн эсрэг тэмцэх ажиллагаанд нэгэн чухал амжилт гаргасан нь Эрүүл мэндийн яамнаас бруцеллёзийн стандарт гаргаж уг өвчний эмчилгээ, оношилгооны заавар удирдамжийг албан ёсоор баталсан явдал бөгөөд эдгээр стандартын дагуу уг өвчний дийлэнх тохиолдол (88 хувь) илэрдэг сумдын түвшинд өвчнийг оношлох боломжтой боллоо.

Хөтөлбөрийн үр дүнгүүд:

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ: Малчид, тариаланчдын хөдөлмөрийн бүтээмж дээшиллээ

- ШХА-ийн хамгийн их танигдсан төслүүдийн нэг болох Монгол төмс хөтөлбөр (МТХ) 2014 онд тус улсын төмсний үйлдвэрлэлийн системийг дэмжих чиглэлд бас нэгэн алхам хийсэн нь Дархан-Уул аймаг дахь Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн БНХАУ, БНСУ, ОХУ-ын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран төмс үржүүлгийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн явдал байлаа. Хөтөлбөрөөс төмсний сортыг туршин нутагшуулах үндэсний системийг нэгтгэн бэхжүүлэх, тариаланчдыг чанар сайтай материалаар хангах ажилд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэв. Арван жилийн тэртээ МТХ есөн аймагт үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол одоо бүх аймгийг хамарсан үйл ажиллагаа явуулж байна.
- Хэдийгээр улсын хэмжээгээр төмсний үйлвэрлэлийн системд ахиц дэвшил гарсан боловч өнгөрсөн жилийн ургацаар төмсний дундаж гарц буурсан нь цаг уурын нөхцөл байдал харьцангуй сэрүүн (2012 онд га-гаас 15,1 тонн, 2013 онд 12.3 тонн) байсантай голчлон холбоотой гэж үзэж байна. Гэвч энэ нь тариаланчдын орлогод эерэг нөлөө үзүүлсэн нь төмсний эрэлт өндөр, үнэ тогтвортой байсны үр дүн юм.
- МТХ төмсний салбарт гаргасан ололт амжилтдаа тулгуурлан хүнсний бусад ногооны үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж эхлээд байна. Өнгөрсөн хоёр жилд хүнсний ногооны олон зуун сортыг Монголын хөрсөнд нутагшуулах туршилт явууллаа. Илүү сайн нутагшсан шинэ сортуудыг сонгон авч үр үржүүлэг, түгээлтийн системд оруулснаар үйлдвэрлэл, маркетингийн хувьд бүтээмж дээшлэх боломж олгож эхлээд байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ: Малчид, тариаланчдын зах зээлд нэвтрэх боломж нэмэгдлээ

- Эдийн засгийн орчин ерөнхийдөө муудаж байгааг эс тооцвол 2014 онд ШХА-ийн зорилтот бүс нутгуудын тариаланчдын орлого бага зэрэг нэмэгдсэн. 2013 онд

тариаланч өрхийн жилийн дундаж орлого 6.6 сая төгрөг байсан бол 2014 онд 7.1 сая төгрөг болж өсчээ. Энэ нь төмс, хүнсний ногооны салбарт хадгалах байгууламж, боловсруулах хүчин чадал, зах зээлийн мэдээллийн систем тогтмол сайжирч байгаатай холбоотой.

- 2014 онд ШХА-ийн Ногоон алт төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан баруун аймгуудын 93 сумын Бэлчээр ашиглагчдын холбоотой шууд холбоотой ажилладаг малчдын 61 хоршоо (тэдгээрийн ес нь эмэгтэй тэргүүнтэй) нийт 190 сая төгрөгийн ноогдол ашгийг гишүүддээ олгосон байна. 2013 онд энэ үзүүлэлт 151 сая төгрөг байсантай харьцуулахад жилийн 25 хувийн өсөлттэй гарчээ. Энэ нь малын гаралтай бүтээгдэхүүнийг БАХ-ийн тогтолцоотой харилцан уялдаатайгаар нэгтгэн цуглуулж, хамтран борлуулж буй хоршоодын ач холбогдол улам бүр нэмэгдэж байгааг тод харуулж байна.
- Монгол малчдад эдийн засгийн үр өгөөжөө өгч буй нэг мал бол сарлаг юм. Ногоон алт төсөл сарлагийн хөөврийн маркетингийг сайжруулах замаар малчдын орлогыг дээшлүүлэх боломжийг олж харсан билээ. 2014 онд анх удаа 3000 малчин (тэдгээрийн 40 хувь нь эмэгтэй) 11 хоршооны (гурав нь эмэгтэй тэргүүнтэй) зохион байгуулалтад орж ажиллан Улаанбаатарын 15 боловсруулах үйлдвэрт (тэдгээрийн 70 хувь нь эмэгтэйчүүд) 48 тонн сарлагийн хөөвөр борлуулжээ. Боловсруулах үйлдвэрүүдийн үзэж байгаагаар малчдын хөөвөр самнах, ангилах үр чадвар дээшилсний үр дүнд нийлүүлж байгаа хөөврийнх нь чанар сайжирсан байна. Малчид нэгдэн нийлүүлэгчийн зохион байгуулалтад орсноор боловсруулах үйлдвэрүүдтэй сайтар үнэ тохирох боломжтой болсон бөгөөд 2013 онд нэг кг нь 10,000 төгрөг байсан хөөврийн үнэ 2014 онд 15,000 төгрөг болж өсчээ. Төсөлд хамрагдаагүй бусад газруудад ч энэ үнэ үйлчилж байгаа учраас сарлагийн хөөвөр үйлдвэрлэгчдийн 2014 оны орлого өмнөх оныхтой харьцуулахад 50 хувь өссөн гэсэн үг юм.


АМЬЖИРГАА: Малчид, тариаланчдын амьжиргааны тогтвортой байдал дээшиллээ



© ШХА

Хөвд аймгийн ногоочид: ШХА-ийн Монгол төмс хөтөлбөр хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж эхэллээ

Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн (БАХ) удирдлагын түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо



- БАХ-үүдийн гол зорилго бол бэлчээрийн менежментийг сайжруулах явдал. Үүнийг бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гаргаж, малчид, орон нутгийн удирдлагуудын хооронд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах замаар хэрэгжүүлж байна. БАХ-ийн холбоо, орон нутгийн захиргааны хооронд харилцан тохиролцож байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний тоо 2013 онд 396 байсан бол 2014 онд 525 болж нэмэгдсэн бөгөөд 2013 онд Монгол орны баруун ба төв бүсийн нийт 5,8 га бэлчээрийг хамарч байсан бол энэ онд 6,3 га бэлчээрийн газрыг хамруулжээ.
- ШХА-ийн Малын эрүүл мэндийн төсөл хүн, малыг бруцеллэз өвчний халдвараас ангижруулахад чухал ач холбогдол өгч байна. Төслөөс үзүүлж буй дэмжлэгийн үр дүнд малчид уг өвчнийг орон нутагтаа оношлуулж, эмчлүүлэх боломжтой болж байна. Бруцеллэз өвчин хүнд халдварласан тохиолдлыг илрүүлэх хувь 2013 онд 66 хувь, 2014 онд 88 хувь болж өссөн байна.
- Ногоон алт төсөл эмэгтэйчүүдийн манлайлах чадварыг дэмжиж ажиллаж байна. Олон нийтийн ажилд оролцож буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсч, тэд нутгийн иргэдийг удирдан манлайлах үүрэг гүйцэтгэх нь улам бүр нэмэгдэж байна. БАХ-ийн тэргүүнээ ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо 2013 онд 19,4 хувь, 2014 онд 21,5 хувийг эзлэх боллоо. 2014 оны байдлаар нийт 800 БАХ-ийн 86-г эмэгтэйчүүд удирдаж байна.
- Малын эрүүл мэндийн төслийн ачаар Эрүүл мэндийн яамнаас бруцеллэзийн үндэсний стандартыг баталж сумдын түвшинд хийгдэх эмчилгээ, оношилгоог зохицуулж байгаа бөгөөд энд уг өвчний гаралтын 88 хувийг орон нутагт оношилж байна. Бүх сумын хүн эмнэлгийн эмч нарыг бруцеллэзийн оношилгооны сургалтад хамруулснаар малчид, хөдөөгийн алслагдмал газрын иргэд уг өвчнийг ямар нэг зардалгүйгээр эрт оношлуулах боломжтой боллоо.
- Малыг даатгуулна гэдэг нь малчдыг байгалийн гамшгаас хамгаалж, тэдэнд учрах эдийн засгийн хохирлыг бууруулна гэсэн үг. 2014 онд нийт малчин өрхийн 10 хувь, нийт малын 7.7 хувийг даатгалд хамруулсан бол 2013 онд энэ үзүүлэлт тус тус 13.5 хувь, 8.5 хувь байжээ. Ийнхүү буурсан шалтгаан нь өнгөрсөн хэдэн жилд цаг агаарын нөхцөл харьцангуй сайн байсан, малын хорогдол маш бага байснаас малчид даатгалын нөхөн олговор бага авсантай холбоотой. 2014 онд Завхан аймгийн Бэлчээр ашиглагчдын 12 хэсгийн 380 малчин хамтын даатгалын арай хямд хэлбэрийг сонгож малаа даатгуулжээ. Урд жил нь хамтын даатгалын энэхүү
- Малыг бруцеллэзийн халдвараас ангижруулах хамгийн үр дүнтэй арга бол жил бүр бүх төлийг вакцинжуулах явдал юм. Өнгөрсөн гурван жил Малын эрүүл мэндийн төсөлтэй хамтран вакцинжуулалтын дараахь серо хяналт шинжилгээг хэрэгжүүлээд байна. Ингэснээр бруцеллэзийн вакцинжуулалтад зохих хяналт тавьж хүн амын дундах бруцеллэзийн тархалтыг тодорхойлох боломжтой болж байна. Мөн Малын эрүүл мэндийн төслөөс бруцеллэзийн эсрэг дархлаажуулалтын кампанит ажлын үр нөлөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тандалтын загвар боловсруулаад байна.



© ШХА

*Төв аймгийн
Өндөрширээт сумын
"Их ам" Бэлчээр
ашиглагчдын
хэсгийн ахлагч
Д.Наянтунгалаа*

САРАНТУЯА: ХАТААСАН НОГОО ЭРЭЛТ ИХТЭЙ БАЙДАГ

Хөвсгөл аймгийн ногоочин Сарантуяа мал маллахын хажуугаар 90-ээд оноос эхлэн өрхийн тариалан эрхэлж, тарьсан ногоогоо гэрийн нөхцөлд хатааж өвөл хүнсэндээ хэрэглэдэг байж.

Одоо тэрээр 1,5 га талбайд хүнсний ногоо тариалж, жилдээ дунджаар 50 тонн ургац хураадаг ногоочин болжээ.

Гэрийн нөхцөлд ногоо хатааж хадгалдаг байсан туршлагадаа үндэслэн хүнсний ногоо хатааж боловсруулах өөрийн гэсэн технологитой болжээ. Түүний хатаасан олон төрлийн хүнсний ногоо нь өнгөрсөн долоон жилийн хугацаанд орон нутгийнхаа хэрэглэгчид болон аймагт нь олноороо ирэх жуулчдын дуртай бүтээгдэхүүн болж хэдийнэ олонд танигджээ.

Бизнесээ өргөжүүлэхийг хүсэх ч түүнд шинэ тоног төхөөрөмж авах боломж хомс байлаа. Харин ШХА-ийн Монгол төмс хөтөлбөрөөс олгосон 10 гаруй сая төгрөгийн тэтгэлэгээр Сарантуяа тоног төхөөрөмжөө сайжруулж, цехийн үйл ажиллагаагаа өргөтгөв.

Өмнө нь өдөрт 10 кг ногоо боловсруулдаг байсан бол шинэ тоног төхөөрөмжийн ачаар өдөрт 80-100 кг ногоо боловсруулах болжээ.

Шинэ хүнсний ногоо ховорддог өвлийн улиралд монголчуудын хэрэглэх тэжээллэг хүнсний нэр төрлийг олшруулж буй хатаасан ногоо зах зээлд эрэлт ихтэй байгаад Сарантуяа сэтгэл хангалуун байна.

Ногоочин Сарантуяа хүнсний ногоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна

© ШХА



Мэргэжлийн боловсрол, сургалт



Хөтөлбөрийн ОНЦЛОХ ҮР ДҮНГҮҮД:

ШХА-ын дэмжлэг туслалцаа, үйл ажиллагааны үр дүнд МБС-ын салбарт үндэсний хэмжээнд дагаж мөрдөх албан ёсны стандарт арга зүй бий болоод байна. МБС-ын төслөөс боловсруулсан ажил, мэргэжлийн стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй болон загварыг Хөдөлмөрийн сайд баталж, улмаар үндэсний хэмжээнд мөрдөж ажиллахыг үүрэг болсон. Үүний үр дүнд Авто замчдын холбоо дээрх арга зүй, загварыг ашиглан салбарынхаа мэргэжлийн стандартыг боловсруулж байна. Ийнхүү ажил олгогчид, мэргэжлийн холбоодын боловсруулсан ажил, мэргэжлийн стандарт нь чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах үндэс суурь болох юм.

ШХА-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан МБС-ын хөтөлбөрүүд, ур чадвар олгох богино хугацааны сургалтуудыг төслийн түнш байгууллагууд хэрэгжүүлж байна. ШХА-тай хамтран ажиллаж буй Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ) зургаан үндсэн мэргэжлээр иж бүрэн сургалт явуулахын зэрэгцээ барилга, механикийн чиглэлээр ур чадвар олгох богино хугацааны дамжаа хичээллүүлж байна.

ШХА-ийн зорилтот бүс нутгуудад эрэлтэд чиглэсэн МБС-ын тогтолцоо бий болгоход хувийн хэвшлийнхэн улам бүр өргөнөөр оролцож байна. Өнөөдөр зорилтот бүс нутгийн хөдөөгийн хүн амын дунд МБС-ын салбарыг улам бүр хүлээн зөвшөөрч үнэлэх болсон нь 2014 онд бие даасан судалгааны байгууллагын судалгаагаар тогтоогджээ.

Монголд шинээр хөгжиж буй амьдрах ухааны чадварууд, түүнд суурилсан эрүүл мэндийн боловсролыг боловсролын үндсэн системд нэвтрүүлээд байна. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр амьдрах ухааны болон түүнд суурилсан эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын Боловсролын их сургуулийн сургалтын хөтөлбөрт заавал судлах судлагдахуун болгон батлуулсан байна.

Жендерт суурилсан хүчирхийллийн (ЖСХ) тухай олон нийтийн анхаарлыг хандуулан, мэдлэг, мэдээлэл хүргэснээр нийгэмд энэ асуудлын талаар ойлголт сайжирсаар байна. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрөөс ЖСХ-ийг үл тэвчих нийгмийн хэм хэмжээг тогтоох, энэ төрлийн хүчирхийллээс сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх, өртсөн тохиолдолд тусламж эрэлхийлэх зан үйлийг хэвшүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг манлайлан хэрэгжүүлээ.

Хөтөлбөрийн үр дүнгүүд:

Мэргэжлийн боловсрол сургалт: Баруун зургаан аймгийн МСҮТ, коллежид хамрагдсан залуусын ажил эрхлэх боломжийг дээшлүүлээ

- ШХА-аас 2014 онд хэрэгжүүлсэн ажлуудын нэг чухал үр дүн бол МБС-ын төслөөс боловсруулсан ажил, мэргэжлийн стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй болон загварыг үндэсний хэмжээнд мөрдөж ажиллахаар болсон явдал юм. Ажил, мэргэжлийн стандарт боловсруулах арга зүй, загварыг ажил олгогч, мэргэжлийн холбоод сайшаан хүлээж авч, мэргэжлийн стандартаа боловсруулж байна. Мөн тэдгээрийг үндэслэн Хөдөлмөрийн яамнаас чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах загварын дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах томоохон зорилт тавин ажиллаж байна.
- ШХА-ийн дэмжлэгтэйгээр баруун бүсийн Мэргэжлийн боловсрол, сургалтын долоон байгууллагад сургалтын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсний үр дүнд чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу бодит ажлын орчинд мэргэжлийн сургалтыг тогтвортой явуулах боломж бүрдсэн.
- Засгийн газар, олон талт хандивлагчдын дэмжлэгтэйгээр МБС-ын салбарт хийж буй шинэтгэлийн үр дүнд хувийн хэвшлийн компаниуд МСҮТ-үүдтэй хамтран ажиллах сонирхолтой болж, тэдний зүгээс ШХА-ийн дэмжлэгтэй ажиллаж буй төвүүдтэй түншлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэх болсон нь эрэлтэд чиглэсэн боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаагийн үр дүн юм. 2014 он байдлаар ШХА-ийн дэмжлэгтэй зургаан МСҮТ-тэй хамтран үйлдвэрлэлийн дадлагын сургалт явуулахад оролцсон түнш үйлдвэр, аж ахуйн тоо өмнөх жилийнхтэй харьцуулахад даруй 169-өөр нэмэгдсэн байна.

МБС-ын төсөлд хамрагдсан Баян-Өлгийн аймгийн МБСТ-ын авто зам засварын ангид суралцаж буй залуус

© ШХА



*Залуучуудын
хөгжлийн хөтөлбөр
нь мянга мянган
залуучуудад амьдрах
ухааны боловсрол, ур
чадвар олгож байна.*

© Дастин Бартер / НҮБХАС



- ШХА-ийн МБС-ын дэмжсэн төслүүд зөвхөн залуусын техник, мэргэжлийн боловсролын асуудлыг хөндөөд зогсохгүй нөхөн үржихүйн эрүүл мэнд, нийгмийн чадварыг хөгжүүлэхэд анхаарч байна. Монгол улсын Боловсролын Их сургуулиас сургалтын хөтөлбөртөө “Эрүүл мэнд, амьдрах ухааны боловсрол” хичээлийг оруулж тус сургуульд суралцагч бүх оюутан (3000 оюутан) хоёрдугаар дамжаандаа хоёр кредит цаг суралцах боломж олгож байна. Энэ нь ШХА-ийн дэмжлэгтэй ЗХХ-ийн нөлөөллийн үйл ажиллагааны шууд үр дүн юм.
- ШХА-ийн зүгээс НҮБ-ын Хүн амын сантай түншлэн амьдрах ухааны чадвараар дамжуулан залуусыг хөгжүүлэх таатай боломж, хэрэгсэлүүдээр хангахаар ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд төв, орон нутгийн засгийн газартай хамтран Залуучуудын хөгжлийн 14 төв (ЗХТ) байгуулахаар төлөвлөсний тавыг нь 2014 онд баруун аймгуудад нээн ажиллуулаад байна. Эдгээр ЗХТ-д 15-34 насны 45,000 гаруй залуус (тал хувь нь эмэгтэй) хамрагдах боломжтой боллоо.
- ЗХХ-ийн санаачилсан “Цагаан тууз” кампанит ажлыг (Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 өдрийн идэвхтэй үйл ажиллагаа) уг хөтөлбөрийн үндэсний түнш болох Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс зохион байгууллаа. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой асуудлуудаар олон нийтэд мэдлэг олгох

энэхүү кампанит ажил Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэмжлэгийг авч, тэрээр нийгэмд ийм хүчирхийлэл газар авч байгааг ноцтой буруушааж, нийгэмд гүн бугшсан энэ асуудлыг хамтран шийдвэрлэхийг бүх талуудад хандан уриаллаа.

Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх богино хугацааны сургалтууд: Мэргэжлийн ур чадвар дутагдаж буй иргэдийн ур чадварыг богино хугацаанд хөгжүүлж, тэдний ажил эрхлэх боломжийг дээшлүүлэв

ШХА-аас Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-тэй хамтран хэрэгжүүлж буй Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх төслийн дэмжлэгтэйгээр баруун бүсийн зургаан МСҮТ-д барилга, механикийн чиглэлээр богино хугацааны ур чадвар олгох сургалтууд явуулж эхэллээ. Техникийн олон янзын чиглэлээр ур чадварын дэмжлэг үзүүлсний үр дүнд багш, сургагч нарын өөртөө итгэх итгэл дээшилж, төвүүд нь чанартай сургалт мэргэжлийн өндөр түвшинд явуулах чадвартай боллоо. Түүнчлэн ажлын байранд дадлагын хичээл зааж буй сургагч багш нартай хамтран МСҮТ-д суралцагчдын ур чадварыг дээшлүүлэхэд үйлдвэрийн дадлагажуулагч багшийн сургалтын тогтолцоо бий болгохоор ажиллаж байна.

ЦЭГМИД: БИ ТУСЛАХ АЖИЛЧИНААР ЭХЭЛСЭН. ХАРИН ОДОО БАРИЛГЫН ДОТООД ЗАСАЛ ЧИМЭГЛЭЛ ГЭЭД БҮХНИЙГ ХИЙЖ СУРЧ БАЙНА.

“Манайх Завхан аймгаас нэлээд зайдуу суманд амьдардаг малчин айл. Аав маань архи уухаараа агсан согтуу тавьдаг болохоор би аавтайгаа таарамж муутай. Тиймээс би гэртээ эргэж харихыг хүсэхгүй байгаа” гэж Хүүхдийн өргөө төвд амьдарч буй Цэгмид ярилаа. Тэрээр энэ жил 18 нас хүрч байна.

“Би өнгөрсөн хоёрдугаар сарын 10-нд Улаанбаатарт ирсэн. Хүүхдийн өргөө ТББ-ийн зуучилж тусалснаар барилга дээр дагалдан ажилтнаар ажиллах болсноор би ажил мэргэжилтэй боллоо. Одоо Зайсан дахь барилга дээр ажиллаж байна. Би эхлээд туслах ажилчинаар орсон. Харин одоо барилгын дотоод засал чимэглэл гээд хийхгүй юмгүй болсон.”

“Би цаашдаа барилгын инженер болохоор суралцана. Өөрийн гэсэн барилгын компани байгуулаад Монгол Улсынхаа барилгын салбарын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулна гэж мөрөөддөг. Би гэрийнхнээ, ялангуяа хоёр дүүдээ туслахыг л хүсч байна.”

Хүүхдийн өргөө ТББ нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, орон гэрээсээ дайжсан өсвөр насныхныг амьдрах байраар хангаж, мэргэжлийн ур чадвар эзэмшихэд тусалж байна.

“Бид зөвхөн байраар хангаад зогсохгүй залуустаа мэргэжлийн боловсрол олгож, аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн дадлага хийж, мэргэшиж, улмаар ажилтай болгоход нь анхаарч ажилладаг” гэж тус төвийн тэргүүн Нордэрмаа ярилаа.

“Манай төвд амьдарч буй залуусын дийлэнх нь баруун аймгуудаас ирсэн. Өнгөрсөн жилийн 103 хүүхдийн 15 нь эндээ амьдарч байна. Бусад 87 нь аль хэдийн ажилтай болсон. Тэдний 27 нь Улаанбаатарт үлдэж, бусад нь нутагтаа ажиллаж байна.

Үйлдвэр, аж ахуйн нэгжид дадлагажигчаар орж ажиллах нь хүүхдүүдэд мэргэжил эзэмшиж, ажилтай болоход маш их тустай гэж Нордэрмаа захирал онцоллоо.

Мэргэжлийн сургалтын төвд суралцагсдыг ажлын байран дахь дадлага хийх боломж олгож, төгсөхөд нь ажил олгогчдод зуучлах систем Монголын Мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоонд дутагдаж байна.

“Манай компани залуучуудын бизнесийн ур чадварыг дэмжихийг зорьдог” гэж Хүүхдийн өргөө төвийн залууст үйлдвэрлэлийн дадлага хийж, дагалдан ажилчинаар ажиллах боломж олгосон Хасу Цамхаг компаний захирал Дэлгэрсайхан хэллээ.

ШХА-аас санхүүжүүлж буй НҮБХАС-ын Залуучуудын хөгжлийн хөтөлбөр нь Хүүхдийн өргөө төвийн энэхүү сайн туршлагыг дэлгэрүүлэн, эмзэг бүлгийн залууст мэргэжлийн ур чадвар эзэмшиж, улмаар үйлдвэрлэлийн дадлага хийх боломж олгох нь тэднийг ажилтай болгох нэг боломж гэж үзэж дэмжин ажиллаж байна.

Хүүхдийн өргөө ТББ-ын дэмжлэгээр гэр бүлийн хүчирхийллээс зугтсан залуус амьдрах байртай болоод зогсохгүй амьдралын арга ухаан, мэргэжлийн ур чадварт суралцаж байна.

© Дастин Бартер / НҮБХАС



Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал ба иргэний оролцоо



Хөтөлбөрийн онцлох үр дүнгүүд:

Орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын төслийг иргэдийн оролцоотойгоор сонгох олон нийтийн хэлэлцүүлгийн чанарт ахиц гарлаа. Нийт 64 хэлэлцүүлгийг зохион байгуулах, хөтлөн явуулахад дэмжлэг үзүүлж ажилласны үр дүнд найман тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 313 төсөл Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) хөрөнгө оруулалтаар хэрэгжих боллоо.

Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын (ИТХ) хууль тогтоох, хяналт тавих, төсөв батлах чиг үүрэг бэхжиж байна. Тухайлбал, ИТХ-ын чадавхи бэхжүүлэх үндэсний сургалтад орон нутгаас сонгогдсон иргэдийн төлөөлөгчдийн 86.6 хувь нь хамрагдаад байна.

Худалдан авах ажиллагааг илүү өрсөлдөөнтэй, ил тод болгосноор улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил үйлчилгээний гүйцэтгэлийн зардал буурлаа. ШХА-ийн төсөл хэрэгжиж буй 13 аймагт гүйцэтгэлийн зардал 10-15 хувь буурсан тооцоотой байна.

Нэг цонхны үйлчилгээний (НЦҮ) төвөөр үйлчлүүлэгч иргэдийн сэтгэл ханамжийн түвшин 2013 онд 76 хувь байсан бол 2014 онд 79 хувь болж өслөө.

Санхүү, эдийн засгийн дээд сургууль төрийн бус байгууллагын удирдлагын чиглэлээр магистрийн зэрэг олгох сургалтыг 2014 оны дөрөвдүгээр сараас эхлэн явуулж анхны элсэлтдээ 20 оюутан (тэдний 13 нь эмэгтэй) элсүүлсэн байна.

Хөтөлбөрийн үр дүнгүүд:

ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛ: Орон нутгийн засаглал, хариуцлагын тогтолцоо сайжирч байна

- Швейцарь бол шууд ардчилал, сайн засаглалын практикийг нэвтрүүлэх Монгол Улсын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлж буй гол түнш улс билээ. Төвлөрлийг сааруулах, орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс хуваарилдаг ОНХС-ийн талаар иргэд илүү мэдээлэлтэй болсон байна. Мөн түүнчлэн иргэд ОНХС-ийн төлөвлөлтөд оролцож байгаадаа ихээхэн сэтгэл ханамжтай байх болжээ. ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн нийтийн хэлэлцүүлгийн чанарыг сайжруулах чиглэлээр ШХА-ийн Засаглалыг сайжруулах, төвлөрлийг сааруулах хөтөлбөрөөс (ЗТСХ) орон нутгийн удирдлагад дэмжлэг үзүүлж байна. ЗТСХ-ийн дэмжлэгтэйгээр 17 сумдын ОНХС-ийн хэлэлцүүлгийг хөтлөн явуулахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд 2013 онд дөрвөн тэрбум төгрөгийн өртөгтэй 151 төсөл, 2014 онд найман тэрбум төгрөгийн өртөгтэй 313 орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл батлагджээ. Үүнд бэлчээрийн менежмент, орон нутгийн үйлчилгээний хүртээмж, иргэдийн өргөдөл барагдуулах механизм зэрэг олон төсөл орсон байна. Төслийн сумд иргэдийн саналд тулгуурлан газар ашиглалт, усны нөөцийн менежмент, нийтийн тээвэр, бэлчээрийн менежмент зэрэг олон чухал асуудлаар дүрэм журам боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна.
- ШХА-аас шийдвэр гаргалт дахь иргэдийн оролцоог дэмжих үүднээс орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийг сургах, чадавхижуулах чиглэлээр НҮБХХ-тэй хамтран ажиллаж байна. Тус байгууллагатай хамтарсан Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх төслөөс ОНХС-ийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээнд хяналт тавих талаар орон нутгийн хурлуудад дэмжлэг үзүүлэв. Төслөөс орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдөд зориулсан үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөрийг анх удаа боловсруулж, сургалт зохион байгууллаа. Хөтөлбөрийг Удирдлагын Академийн хичээлийн хөтөлбөрт оруулахаар ажиллаж байна.
- ШХА-ийн санаачлан эхлүүлсэн Нэг цонхны үйлчилгээний (НЦҮ) төвүүд 2007 оноос эхлэн төрийн үйлчилгээг иргэдэд ойр дөхөм, чирэгдэлгүй хэлбэрээр үзүүлж ирсэн. Засгийн газар ч НЦҮ-г дэмжин улсын хэмжээнд нэвтрүүлэн урт хугацааны тогтвортой ажиллагааг хангахуйц санхүүжилт олгохоо илэрхийлсэн. Судалгаанд хамрагдсан НЦҮ-ний 22 төвийн 14-ийнх нь үйл ажиллагаа, урсгал засварын зардлыг 2014 оны төсөвт багтаан санхүүжүүлжээ. Түүнчлэн нийт НЦҮ-ний төвүүдийн 24 хувь нь урсгал зардлаа 2014 оны орон нутгийн төсөвт тусгайлан суулгуулсан байна.
- 2014 оны эхний хагаст улсын хэмжээгээр НЦҮ-ний 41 төв ажиллаж нийт 845,000 иргэнд (57 хувь нь эмэгтэй) үйлчилсэн бол түүний өмнөх жилийн мөн үед НЦҮ-ний 31 төвөөр нийт 638,000 иргэн (55 хувь нь эмэгтэй) үйлчлүүлж байжээ. 2013-2014 онд НЦҮ-ний төвүүдээр үйлчлүүлэгсдийн сэтгэл ханамжийн түвшин 76 хувиас 79 хувь болж өсчээ.
- ШХА, ГОУХАН-ийн хамтран санхүүжүүлсэн Эрчим хүчний үр ашиг төсөл (ЭХҮАТ) баруун бүсийн хамгийн хүйтэн, алслагдмал сумдын хүүхдийн цэцэрлэгийн барилгад дулааны алдагдлыг бууруулах загварыг туршин үзүүлсэн нь төсвөөс эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах боломжийг харуулсан оновчтой загвараар тодорлоо. Эрчим хүчний хэмнэлт бүхий технологи ашиглан төрийн өмчит барилга байшингийнхүү дулаалан, сэргээн засварласан нь хөдөөгийн хүн амд олон талын ашиг тусаа өгч байна. Өмнө нь өвөлдөө -10-15 хэм

Иргэд олон нийтийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцдог боллоо.

© Л.Элбэгзаяа / Гамма фото агентлаг



Дулааны алдагдалгүй болгон сэргээн засварласан цэцэрлэгийн хүүхдүүд тав тухтай орчинд сурч боловсорч байна

© ШХА



байдаг байсан цэцэрлэгийн байранд одоо гадаа -10 хэм хүйтэн байхад дотор +25 хэмийн дулаанд хүүхдүүд тухалж байна. Төслөөс өвлийн цагт хэрэглэдэг дулааны алдагдлыг бууруулах, доторхи дулааныг сайжруулах, улмаар бидний амьдралын хамгийн чухал нөөц болох эрчим хүчийг хэмнэх загварыг хэрэгжүүлэх боломжтойг харуулсан. Энэхүү төсөл эрчим хүчний үр ашгийн тухай ойлголтыг нэвтрүүлээд зогсохгүй орон нутгийн захиргаа нутгийн ард иргэдийнхээ оролцоотойгоор ОНХС-ийн хөрөнгөө хэрхэн оновчтой зарцуулахаа шийдэх бодит боломжийг олгож байна.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХӨГЖИЛ: Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, нийгмийн хариуцлага сайжирлаа

- 2014 оноор дуусгавар болсон ШХА-ийн ТББ-дын чадавхийг бэхжүүлэх төсөл өмнө нь төлөвлөгдөөгүй нэгэн нааштай үр дүнд хүрлээ. Энэ нь Санхүү, эдийн засгийн дээд сургууль Монголд анх удаа ТББ-ын удирдлагын чиглэлээр магистрийн зэрэг олгох хөтөлбөртэй болсон явдал юм. Тус төслийн хамтрагч түнш Женевийн Их сургуулийн ижил төстэй сургалтын хөтөлбөрийн дагуу загварчилсан энэхүү зэрэг олгох хөтөлбөр 2014 онд анхныхаа элсэлтийг авч 20 оюутантай (13 нь эмэгтэй) болсон байна. Уг төслийн үндсэн зорилго иргэний нийгмийн байгууллагуудын дотоод удирдлагын чадавхи, засаглалын бүтцийг бэхжүүлэхэд оршиж байв.
- ШХА-ын засаглалыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын тендер шалгаруулалт, худалдан авалтын үйл ажиллагааг сайжруулахаар

ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалт, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт тавьж бизнесийн өрсөлдөөнт, шударга байдлыг хөхиүлэн дэмжихэд Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дэмжих төсөл онцгой анхаарч байна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш төсөл хэрэгжиж буй 13 аймгийн тендер шалгаруулалт илүү өрсөлдөөнтэй, ил тод болж байгаагийн үр дүнд орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэх ажил үйлчилгээний зардал 10-15 хувь буурч байна.

- Уг төслийн дэмжлэгээр төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, үйлчилгээний тендер шалгаруулалт, худалдан авалтад ИНБ-ууд хяналт тавьдаг бөгөөд төсвийн хөрөнгийг зохисгүй ашигласан найман тохиолдлыг илрүүлжээ. Үүний үр дүнд төсвийн хөрөнгөөр барилга барьж буй ханган нийлүүлэгчид чанар сайтай материал ашиглах болсон байна.
- Төслийн дэмжлэгээр аймгууд нээлттэй тендер шалгаруулалтыг 199 удаа явуулж, нийт 227 гэрээ байгуулсан байна. Түүнчлэн төрөөс бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажил үйлчилгээний гэрээг орон нутгийн 150 аж ахуйн нэгж, 77 ИНБ-тай байгуулж, тэд нийт 14.6 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн бол 2013 онд 10.3 тэрбум төгрөгийн өртөгтэй 115 гэрээ байгуулж байжээ.

Б. АМГАЛАН: ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ИЛТ САЙЖИРСАН

“Худалдан авалтын нээлттэй тогтолцоотой болохоос өмнө байдал өөр байсан” гэж Увс аймгийн нэгдүгээр сургуулийн иж бүрэн засварын ажлыг гүйцэтгэсэн Ундрах бүтээмж ХХК-ийн захирал хатагтай Б.Амгалан хэллээ. “Худалдан авалтын хуучин практикт шийдвэрлэвэл зохих олон чухал асуудал байсан. Харин одоо Худалдан авах ажиллагааны газраас манай аймагт явагдах тендерийн боломжуудын талаар мэдээлэл сайн өгдөг болсон” гэв.

Ундрах бүтээмж ХХК нь тус аймагт ажиллаж байсан улсын барилга трестийн бааз татан буугдаж, олон жижиг хувьцаат компани болж салсан 1990-өөд оны дунд үеэр уг баазын суурин дээр байгуулагджээ. Эдүгээ тус компани 40 гаруй ажилтантай бөгөөд тэдний дотор өмнө нь төрийн өмчит компанид ажиллаж байсан чадварлаг, туршлагатай хүмүүс бий.

Саяхан аймгийн Худалдан авах ажиллагааны газраас www.uvstender.mn вэбсайт ажиллуулж эхэлсэнийг Б. Амгалан захирал ихээхэн сайшаав. Уг вэбсайт төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны тендерт оролцогчдод шаардлагатай мэдээллээр хангадаг байна. “Бид сургуулийн засварын ажлын сонгон шалгаруулалтад оролцохдоо зах зээлийн үнэд тулгуурласан хамгийн бодитой үнэ санал болгосон гэж боддог. Манай санал болгосон төсөв уг тендерийн анхны үнээс 50 сая төгрөгөөр хямд байсан. Ингэснээр бид аймгийнхаа төсвийг 50 сая гаруй төгрөгөөр хэмнэлээ гэсэн үг. Гэсэн ч бид ажлаа чанартай хийж гүйцэтгэсэн” гэж ярилаа.

2013 оны жилийн эцсийн тайлангаар Увс аймгийн гэрээт ажлын зардал 11 тэрбум төгрөгөөс 0.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Мөн энэ хугацаанд худалдан авах ажиллагааны үр дүнгийн чанар, төслийг хугацаанд нь гүйцэтгэх чадвар ч сайжирчээ.

Мөн худалдан авах ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) оролцож олон нийтийн хяналт тавих болсон байна.

“Тендерийн хорооныхон манай компанийн чадавхи, өмнө хийсэн ажлын туршлагатай танилцаад энэ засварын ажлыг гүйцэтгэх чадвартай гэж үзсэн гэдэгт итгэлтэй байна” гэж Б. Амгалан хэлэв.

“Сонгон шалгаруулалтын ажиллагаанд ИНБ-ууд оролцож байгаа нь маш сайн хэрэг. Тэд шалгаруулалтыг шударга, бодитой явуулахад тусладаг. Цаашид үүнд оролцож байгаа ИНБ-уудын тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж би үзэж байгаа. Бас нэг чухал зүйл бол орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг татан оролцуулж худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд өгч байх хэрэгтэй.”

“Ундрах бүтээмж” компани нэгдүгээр сургуулийн барилгын дээвэр, шалыг засч, цонх, хаалгыг сольсны зэрэгцээ бүхий л дотоод заслыг хийж гүйцэтгэсэн байна. “Манай сургуулийн засварын ажлыг чанартай сайн хийсэнд бид сэтгэл ханамжтай байгаа” гэж тус сургуулийн захирал Н.Бүрэн ярьсан юм.

Увс аймагт худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг нээлттэй, өрсөлдөөнтэй, оролцоотой явуулах болсноор төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаанд өөрчлөлт гарч байна. “Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа илт сайжирсан” гэж хатагтай Амгалан хэллээ.

*Увс аймгийн
Улаангом сумын 1
дүгээр сургуулийн
сурагчид шинэхэн
сургуультай
болсондоо баяртай
байна*

© ШХА



Тогтвортой бичил уурхай



Хөтөлбөрийн ОНЦЛОХ үр дүнгүүд:

*Баянхонгор
аймгийн Баян-
Овоо суманд үйл
ажиллаж буй бичил
уурхайчдын “Ундарга”
нөхөрлөлийн хамт
олон аюулгүй
ажиллагаа, хөдөлмөр
хамгааллыг хангахад
ихээхэн анхаарч
ажилладаг*

© ШХА

2014 онд ШХА-ийн Тогтвортой бичил уурхай төслийн дэмжлэгтэйгээр ашигт малтмалын бодлого, хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтөд Бичил уурхайн асуудлыг тусган орууллаа. Бичил уурхай эрхлэгчдийн сайн сайхан байдлыг сайжруулахад нөлөөлсөн бусад үр дүнд бичил уурхайчид эрүүл мэнд, нийгмийн даатгалын схемд хамрагдах нь нэмэгдсэн, БУ-гаас олборлосон алтны борлуулалт эрс өссөн, ашиглах газрын хэмжээ нэмэгдсэн, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын мэдлэг, туршлага дээшилсний үр дүнд уурхайн осол аваарын тоо буурсан зэрэг амжилтыг нэрлэж болно.

Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх II (БОХТОН II) төслөөс бага орлоготой бичил уурхай эрхлэгчдэд зориулан байгаль орчны нөхөн сэргэх чадвар, эдийн засгийн боломж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хослуулсан нөхөн сэргээлтийн хямд төсөр, шинэлэг аргачлалыг боловсруулсан нь тэдэнд зориулсан, мөн экологид ээлтэй ажлын байр бий болгох боломжтойг харуулж байна.




Хөтөлбөрийн үр дүн:

- 2014 онд ТБУ төслөөс бичил уурхайн эрх зүйн орчныг сайжруулах талаар олон санал зөвлөмж гаргаснаар багагүй эерэг үр дүн гарлаа. 2014 оны нэгдүгээр сард батлагдсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод бичил уурхайн талаар баримтлах урт хугацааны бодлогоо тодорхойлсон бөгөөд Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайгаар олборлосон алтны борлуулалтын асуудлыг оруулж албан ёсны борлуулалтыг дэмжин хялбаршуулах үүднээс өмнө байсан 300 граммын худалдааны босгыг байхгүй болголоо. Мөн Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр албан ёсоор уурхайн газар эзэмших боломжийг сайжруулж, бичил уурхайг өргөжүүлэн хоршооллын зохион байгуулалтад орох боломж олголоо.
- ШХА-ийн дэмжлэгээр 2013 онд байгуулагдсан бичил уурхай эрхлэгчдийн


холбоо байгуулагдсан цагаасаа эхлэн эрчимтэй хөгжиж бодлогын чухал оролцогч тал болоод зогсохгүй Монголын бичил уурхайчдын дуу хоолой болж байна. Тус холбоо хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх талаар өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, иргэний нийгмийн бусад байгуулагуудтай хамтран 2014 оны Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт зориулсан Бичил уурхай ба хүний эрхийн тухай тайланг боловсруулж илгээлээ. Холбооны хүчин чармайлтын үр дүнд 2013 онд орон нутгийн бичил уурхайн ТББ-дын тоо 35 байсан бол 2014 онд 45 болж нэмэгдсэн бөгөөд тэд орон нутгийн түвшинд 7085 уурхайчдыг албан ёсны нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах, тэдний эрх ашиг, дуу хоолойг төлөөлөх талаар идэвхтэй ажиллагаа явуулж байна.

Бичил уурхайн 2014 оны бичил статистик



2014 онд бичил уурхайчид нийт 3200 кг алт Монгол банкинд тушаасан

© ШХА



- 2014 онд үндэсний болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд бичил уурхайг хүлээн зөвшөөрч, бичил уурхайчдад үйлчилгээ үзүүлэх нь нэмэгдлээ. ШХА-ийн нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд төрийн захиргааны таван гол байгууллагаас бүрдсэн Бичил уурхайн Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дэд хороо байгуулагдаж аюулгүй ажиллагааны сургалт, үзлэг шалгалт, эрүүл ахуйн үзлэг зэрэг хэлбэрээр бичил уурхайчдад албан ёсны дэмжлэг үзүүллээ. Түүнчлэн Хөдөлмөрийн яамнаас орон нутгийн хөдөлмөрийн байцаагч нарын ажлын байрны тодорхойлолтод бичил уурхайд аюулгүй ажиллагааны дэмжлэг үзүүлэх үүргийг нэмж оруулсан байна.
- Алтны худалдаанд тавигдах саад тотгорыг арилгасны үр дүнд бичил уурхайчдаас улсын нөөцөд оруулсан хувь нэмэр 2013 онд 3,2 кг байсан бол 2014 онд 3200 кг алт болж огцом өссөн бөгөөд өнөөгийн ханшаар нийт 250 тэрбум төгрөгийн өртөг бүхий энэ борлуулалт төв банкинд тушаагдсан нийт алтны 16 хувийг эзлэж байна. Түүнчлэн 2014 оны наймдугаар сарын байдлаар бичил уурхайчдаас анх удаа нийт 6,24 тэрбум төгрөгийн нөөц ашигласны төлбөрийг төрийн санд тушаагаад байна.
- Бичил уурхайн орлого нэмэгдсэнээр албан ёсоор бичил уурхай эрхлэгчдийн амьжиргаа дээшилсээр байна. Албан ёсоор хувиараа алт олборлогчдын сарын дундаж орлого 18 хувиар нэмэгдэж, 2013 онд 952,000 төгрөг байсан бол 2014 онд 1,120,000 төгрөг болжээ. Түүнчлэн, албан ёсны бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааны хөрөнгө (биет, байгалийн, санхүүгийн, нийгмийн, хүний) давхар нэмэгдсэн байна.
- Бичил уурхайг албан ёсны болгох ажиллагаа 2014 онд эрчимжиж нийт 4,639 бичил уурхайчин орон нутгийн захиргаа, том уурхайн компаниудтай аман болон албан ёсны гэрээтэй ажиллаж байгаа бол 2013 онд энэ тоо 3,401 байв. Гурван талт болон аман гэрээгээр албан ёсны үйл ажиллага явуулж буй бичил уурхайчдын тоо 2013 онд 1795 байсан бол 2014 онд 2085 болон өсөн, гурван талт гэрээний тоо долоогоос ес болж өсчээ.
- ТБУ төслийн чадавхийг бэхжүүлэх дэмжлэгийн үр дүнд бичил уурхайн аюулгүй ажиллагаа, нийгмийн хамгаалалд үлэмж ахиц дэвшил гарлаа. 2013-2014 онд нүүрс олборлогчдын амь эрсэдсэн тохиолдол 10-аас дөрөв болж буурчээ. Албан ёсны бичил уурхай эрхэлж буй газруудад хүний амь огт эрсдээгүй байна. 2014 оны наймдугаар сарын байдлаар нийт 4,200 уурхайчин эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдсан нь 2013 оны үзүүлэлтээс даруй 700 хүнээр нэмэгдсэн байна. Түүнчлэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) судалгаагаар, бичил уурхайчдын 81.5 хувь нь орон нутагтаа эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой гэж хариулжээ.
- ШХА-ийн дэмжлэгтэйгээр Монголд байгуулсан мөнгөн усгүй технологиор алтны хүдэр баяжуулах жижиг үйлдвэрийн загварыг Сенегал, Буркина Фасо зэрэг улсуудад хуулбарлан ашиглав. Мөн бичил уурхайн эрүүл ахуйн талаарх Монголын туршлагыг ДЭМБ-аас гаргасан дэлхий нийтийн мэдээллийн эмхтгэлд оруулжээ.

Р.ТҮМЭНДЭМБЭРЭЛ: ЖИРИЙН НЭГ БИЧИЛ УУРХАЙЧИН ЭМЭГТЭЙН “МАНЛАЙЛАГЧ” БОЛСОН ЗАМНАЛ

1990-ээд онд Төв аймгийн Борнуур суманд жижигхэн хүнсний дэлгүүр ажиллуулдаг байсан гурван хүүхдийн эх Р. Түмэндэмбэрэл бүсгүй нэгэн найздаа зээлдүүлсэн барааныхаа мөнгийг авахаар нинжа хэмээн хочлогдсон хувиараа алт олборлогчдын ажиллаж байсан Сүжигт ууланд очжээ. Тэрээр сонин тохиолдлоор бичил уурхайтай холбогджээ.

Найзаасаа өрөндөө авсан хагас шуудай чулуунаасаа 110,000 төгрөгтэй болж тухайн үедээ хоёр машин өвсний үнэд хүрч байсан. Тэр цагаас хойш Түмээ бүсгүй нөхрийнхөө хамтаар бичил уурхайд ажиллах болжээ. Олсон хэдээрээ гэр орноо өөд нь татаж, тун удалгүй гурван хүүхдээ сургуульд суралцуулах, ялангуяа 19 настай охиноо Улаанбаатар хотноо их сургуульд сургах зардал мөнгийг төлөх боломжтой болсон.

2000 оны эхэн үед иргэдийг хувиараа ашигт малтмал олборлохыг хориглодог, тэдний байгаль орчинд үзүүлж буй хор хөнөөлийн улмаас тэдний үйл ажиллагааг төр засгийн зүгээс ямагт таслан зогсоохыг оролдож байв. Энэ үед Түмээ бусад бичил уурхайчдаа уриалан амьжиргааг нь залгуулдаг ажлын байраа хадгалахын төлөө тэмцэхээр эвлэлдэн нэгдэж, бичил уурхайчдын зохион байгуулалтанд ороход нь дэмжиж Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ)-тэй холбох ажлыг хийж эхэлжээ. Ингэхдээ, бичил уурхайд мөнгөн усны хэрэглээнээс татгалзаж, байгаль орчинд хал

багатай, хариуцлагатай олборлолт явуулах талаар бусад уурхайчдаа уриалан дуудаж, Борнуур суманд мөнгөн усгүй технологи бүхий цехийн үйл ажиллагааг эхлүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж чадсан юм.

2013 онд бичил уурхайчдын санаачлагаар байгуулагдсан “Монголын Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” ТББ байгуулагдахад Түмээ тус холбооны удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргаар тус тус сонгогдон одоог хүртэл амжилттай ажиллаж байна.

“ТБУТ-тэй хамтран ажилласнаар би байгууллагын менежерийн хувьд болон хувь хүнийхээ үүднээс олон зүйл дээр хөгжиж дэвшиж байна. Тайлан бичиж холбогдох байгуулагуудад хүргэх, салбарын яамны өндөр албан тушаалтан, бичил уурхай эрхэлж буй энгийн иргэд гээд бүх түвшний хүмүүстэй итгэлтэй, чөлөөтэй харилцаж, ойлголцож чаддаг болсон. Дөнгөж саяхан би Монгол Улсын Бичил уурхайн салбарын хөгжлийн асуудлаар хэвлэлийн бага хурал зохион байгуулж, бичил уурхай дахь аюулгүй ажиллагааны талаар нөхдийнхөө өмнөөс саналаа илэрхийлээд байж байна. Би өөрчлөлтийг бий болгож чадна гэдэгтэй их итгэлтэй болсон. Зүгээр нэг л амьдрахын төлөө зүтгэж явсан бичил уурхайчин энэ хэмжээнд хүрнэ гэж би огт төсөөлөөгүй байлаа” гэж Түмээ өгүүлэв.



© ШХА

*Р. Түмэндэмбэрэл
Монголын Бичил
уурхайчдын Дээвэр
холбоо ТББ-аас
зохион байгуулсан
хэвлэлийн бага
хуралд оролцож
байна*



© ШХА

*Зусландаа буусан
хот айл*

2015 оны төлөв байдал

2015 онд Улаанбаатар дахь Швейцарийн хамтын ажиллагааны газар нь ШХА-ийн Берн дэх төв удирдах газартай хамтран Монгол дахь Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2016 оны стратегид дотоод үнэлгээ хийнэ. Энэхүү тайланг гаргах явцад ажиглагдсан тодорхой өөрчлөлт, зохицуулалтууд болон Монгол Улсад бий болж буй эдийн засаг нийгмийн олон томоохон өөрчлөлтүүдээс үүдэн дээрх үнэлгээг хийж, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл, хэрэгжүүлэх стратегид өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэхийг зорьж байна. 2012 онд батлагдсан хамтын ажиллагааны стратеги нь эдийн засгийн их өсөлтийн үе, ардчилсан институт, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах улс төрийн хүсэл зоригт тулгуурласан байсан. Гэвч түүнээс хойш эдийн засгийн нөхцөл байдал муудсан, нийгмийн тэгш бус байдал нэмэгдэж байна гэж үзэх болсон төдийгүй төрийн удирдлагын зохисгүй асуудал мэдэгдэхүйц илэрч байгаатай холбоотой. Мөн энэхүү үнэлгээгээр одоогийн стратеги хэрэгжсэний дараах хамтын ажиллагааны боломжуудыг эрэлхийлэх юм.

2015 онд хөтөлбөрийн төсөв дээд хэмжээндээ хүрч 21 сая орчин шв.франк зарцуулахаар төлөвлөж байна. Мөн 2015 оноос хоёр шинэ төсөл эхлүүлэхээр тооцож байна. Ирэх жил нийт найман төсөлд үнэлгээ (дунд хугацааны үнэлгээ ба үе шатны төгсгөлийн үнэлгээ) хийгдэнэ.

ШХА-аас төслүүдийн үйл ажиллагааг нэгтгэх, төслүүд хоорондын ба хөтөлбөрийн үндсэн чиглэлүүдийн хоорондын нэгдсэн уялдаа холбоог сайжруулахад онцгой анхаарна. Үүний тулд ШХА-аас ажилтнуудынхаа болон түнш байгууллагуудынхаа төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхийг дээшлүүлэх чиглэлд үргэлжлүүлэн анхаарна.

Түүнчлэн ШХА-аас хамтын ажиллагааны стратегийн нийтлэг сэдэв болох жендерийн тэгш байдлыг хангахад илүү анхаарна. Жендерийн тэгш байдлыг баримтлах чиглэлээр ШХА-ийн ажилтнууд, түнш байгууллагуудад зориулсан зорилтот сургалт явуулж, бүх төслийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд жендэртэй холбоотой тодорхой үйл ажиллагаа тусгах болно.

Товчилсон үгс:

АН	Ардчилсан нам
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОХТОН	Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЭТСХ	Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах
ЗХТ	Залуучуудын хөгжлийн төв
ЗХХ	Залуучуудын хөгжлийн хөтөлбөр
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МТХ	Монгол төмс хөтөлбөр
МУАН	Монголын Үндэсний Ардчилсан Нам
МСҮТ	МБСТ
НЦҮ	Нэг цонхны үйлчилгээ
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОХУ	Оросын Холбооны Улс
СБАХ	Сумын Бэлчээр ашиглагчдын холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
ТБУ	Тогтвортой бичил уурхай
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ШХУ	Швейцарийн Холбооны Улс
ЭХҮАТ	Эрчим хүчний үр ашиг төсөл

Шв.франк ханш

2012 он:
1456 төг/шв.франк

2013 он:
1636 төг/шв.франк

2014 он:
1980 төг/шв.франк